

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
(Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэс)

2024.06.04

Дархан-Уул аймаг

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				Он	Түвшин		
1	АХ-5.6.4, МУХТЖҮЧ- 5.6.2, ЗГҮАХ-4.2.1	Улсын	Сургалтын тоо				<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд шинээр батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г байгууллагын ажилтнуудын саналаар 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.</p> <p>Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр байгууллагын 22 албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдэвт сургалтыг дотоод мэдээллийн цагаар зохион байгуулсан. Мөн Европын холбоо, АЗДТГ-ын хамтарсан санхүүжилттэй “Найрамдал” төслийн хүрээнд 2024.04.04-05-ны өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлага, ёс зүй” сэдэвт сургалтад ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд хамрагдсан. Албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг баримтлан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

2	АХ-6.2.9, МУХТЖҮЧ- 6.2.2, ЗГҮАХ-5.1.7		"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулах талбайн хэмжээ, мянган га				<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 63 дугаар зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болгон зарласан билээ. Энэхүү өдрийг тохиолдуулан байгалаа нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор мод тарих газрыг сонгох, мод үржүүлгийн газраас тарих модоо авах зэрэг бэлтгэл ажлыг хангаж, ирэх 10-р сард Стандарт, хэмжил зүйн нэрэмжит төгөлтэй болох зорилт тавин ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 70%</p>
---	--	--	--	--	--	--	--

ХЯНАСАН:

ДАРГА

Б.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

БҮТЭЭГДЭХҮҮН БАТАЛГААЖУУЛАЛТЫН
МЭРГЭЖИЛТЭН

Д.БОЛОРТУЯА

7.1. Авлигын үзүүлэлтийг сайжруулна.	7.1.1. Авлигын гэмт хэргийг бууруулна.	АХ-5.6.4, МУХТЖҮЧ-5.6.2, ЗГҮАХ-4.2.1	7.1.1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	Авлигын индекс	Эрэмбэ	110	109	500.00	Улсын	Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар
8.1.Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	8.1.1.Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	АХ-6.2.9, МУХТЖҮЧ-6.2.2, ЗГҮАХ-5.1.7	8.1.1.1."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулж, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ	Мянган га	7.1	7.9	1,000.00	Улсын	Байгаль орчин, аялал жуулчлалын яам